


**“АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ” цуврал сэтгүүлийн 2024 оны дугаарт  
эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авна.**



ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Аман зохиол судлалын салбараас эрхлэн гаргадаг “Аман зохиол судлал” цуврал сэтгүүл нь жилд 1 удаа хэвлэгддэг, олон улсын ISSN 2308-281X дугаартай эрдэм шинжилгээний сэтгүүл юм.

Эрхэм судлаачид аа! Та бүхнийг 1959 оноос өнөөг хүртэл тасралтгүй гарч байгаа Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн ууган сэтгүүлийн нэг билээ. Аман зохиол судлаачдын шилдэг өгүүлийг хүлээн авч нийтэлдэг мэргэжлийн индэр болсон энэхүү сэтгүүлийн 2024 оны дугаарт эрдэм шинжилгээний өгүүлэл илгээж нийтлүүлэхийг урьж байна.

“Аман зохиол судлал” цуврал сэтгүүлийн 45-р ботийн өгүүлийг 2024 оны 5 сарын 10 хүртэл [alimaaa@mas.ac.mn](mailto:alimaaa@mas.ac.mn) цахим хаягаар хүлээн авна.

Өгүүлэл хүлээн авах: 2024.01.10 - 2024.05.15

Редакцын зөвлөл хянах: 2024.05.15 - 2024.06.15

Сэтгүүлд тэнцсэн эсэхийг зохиогчид мэдэгдэх: 2024.07.03

Өгүүлийг засах: 2024.07.03 - 2024.08.05

Сэтгүүлийг хэвлэлд бэлтгэх, хэвлүүлэх: 2024.08.05- 2024.09.10

Өгүүлийг зохиогч өөрийн хийсэн судалгааны ажлын үр дүнд үндэслэн бичсэн байх бөгөөд өөр хэвлэлд нийтлээгүй шинэ өгүүлэл байх шаардлагатай. Та бүхэн манай сэтгүүлд нийтлүүлэх өгүүлэл дараах загвар, шаардлагыг чанд баримталж бичнэ үү!

#### **Өгүүлэлд тавигдах шаардлага**

- Эрдэм шинжилгээ, онол арга зүйн өндөр түвшинд бичигдсэн байх;
- Зохиогч өөрийн хийж байгаа судалгааны үр дүнд үндэслэн бичих, гадна дотнын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлэгдээгүй байх;

#### **Өгүүлийн бүтэц:**

- ХУРААНГУЙ (150-200 үгтэй, англи, монгол хэлээр бичсэн байх)
- ТҮЛХҮҮР ҮГ (англи, монгол хэлээр бичсэн байх)
- 1. УДИРТГАЛ
- 2. СУДАЛГААНЫ АРГА, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН
- 3. СУДАЛГААНЫ ХЭСЭГ (Гарчгийг бичсэн байх)
- 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН (ХЭЛЭЛЦҮҮЛЭГ)
- 5. ДҮГНЭЛТ
- НОМ ЗҮЙ гэсэн үндсэн хэсгүүдтэй байна.
- ТАЛАРХАЛ (шаардлагатай бол)
- ХАВСРАЛТ (шаардлагатай бол)

## Өгүүллийн хэлбэр:

Цаасны хэмжээ	A4
Хуудасны тоо	5-8
Цаасны хүрээ	Бүх талаас 25мм (дээд, доод, баруун, зүүн)
Фонт, хэлбэр	Times New Roman, үсгийн хэмжээ 12-p!
Мөр Хоорондын зай	1.0 (space)
Гарчиг	Гарчиг болон судлаачийн мэдээллийг эхний хуудсанд бичнэ. Өгүүллийн нэрийг толгой үсгээр, тод хараар бичиж, дор нь баруун талд зохиогчийн овог нэр, улс, хот, ажил (сургууль, байгууллага)-ын нэрийг бичнэ.
Үндсэн болон Дэд бүлэг гарчиг	Үндсэн бүлгүүдийн нэрийг хуудасны төвд толгой үсгээр бичнэ. Дэд бүлгийн гарчиг нь хуудасны зүүн талд байрлах бөгөөд том үсгээр эхлэн, жижиг үсгээр бичиж болно. Гарчгуудыг 1,1.1, 1.1.1 гэх мэтээр дугаарлана.
Хүснэгт, зураг	Хүснэгт болон зураг нь нэгдмэл дараалсан дугаартай, агуулгаа тодорхойлсон нэртэй байх ёстой. Хүснэгтийн нэрийг дээр нь, зургийн нэрийг доор нь голлуулан бичнэ.
Зүүлт, тайлбар (Footnote)	Үгийн тайлбар, засвар, залруулга, нэмж судлах материалуудын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгөх шаардлагатай бол хэрэглэж болно.

### Эшлэлд дараах загварыг баримтална.

- Аливаа эх сурвалжаас тодорхой мэдээлэл хэсгийг шууд эш татсан, хураангуйлан бичсэн, өөрийн үгээр найруулан бичсэн зэрэг бүх тохиолдолд тухайн эх сурвалжийг бичвэр дотор эшлэх ба ном зүйн жагсаалтад оруулна.
- Wikipedia-аас эшлэл авахгүй.

#### 1. Бичвэр дотор утга санаагаар эшлэхдээ:

Зохиогчийн нэрийн ард хаалтад тухайн бүтээлийн оныг бичнэ. Жишээлбэл: Оросын эрдэмтэн И.В.Кульганек (2017) монгол ардын зүйр цэцэн үг дэх “Аз жаргал” хэмээх ойлголтыг хэд хэдэн зүйлээр тодорхойлсон... гэх мэт.

#### 2. Бичвэр дотор шууд эшлэхдээ:

Хувилбар 1: Хэрэв зохиогчийг өгүүлбэрийн эхэнд дурдан түүний бүтээлээс шууд эшилбэл, эшлэл (40-өөс доош үгтэй)-ийг хашилтад бичиж ард нь хаалтад он, хуудасны дугаарыг бичнэ. Жишээлбэл: П.Хорлоо “Монгол ардын явган үлгэр” номдоо “Адгуусан амьтны үлгэр бол ямар нэгэн амьтдын хоорондын харилцааг нь харуулж байдгаараа хүний нийгмийн амьдралын харьцаан дунд оршиж байгаа дутагдалтай байдлыг шүүмжлэн илрүүлдэг” (1960: 34) гэжээ.

Хувилбар 2: Хэрэв шууд эшлэл нь 35-аас дээш үгтэй бол бичвэрийг хашилтад хийхгүйгээр догол мөрөөр авч налуу үсгээр бичиж, ард нь (Зохиогч, он: хуудас) гэж эх сурвалжийг бичнэ.

Жишээлбэл: “*Жороо үг нь айзам хэмнэлд тааруулан зохиох эвхээс маягийн шүлэг юм. Жороо үгийн онцлог нь нэгт, дээр өгүүлсэнчлэн ердөө айзам хэмнэлд тохируулан шүлэг зохиолгоход зориулагдсан байна. хоёрт, аль жороо үг ямар ч утга илэрхийлэхгүй байгаа нь хэн нэгэн эхний мөрийг гаргаж хэлдэг нь оролцогсод дараагийн мөрүүдийг өрсөлдөн хэлж уралддаг журам байсан болов уу*” (Оюунбадрах, 2007: 118).

#### 3. Олон зохиогчтой бүтээлээс эш татах:

Хувилбар 1: 2 зохиогчтой бүтээлээс эшилсэн бол эшлэх тохиолдол бүрд 2 зохиогчийн нэрийг цуг дурдана. Жишээ: Аман зохиол судлаач Г.Нандинбилиг, С.Дулам нар (2001) Домгийн цаг бол бидний оршин буй цагаас эрс таслагдсан, гарал үүслийн болоод түүнээс ч өмнөх цаг юм.

Хувилбар 2: 3-5 зохиогчтой бүтээлээс эш татвал хамгийн эхний эшлэлийн тайлбарт бүх зохиогчийн нэрийг бичнэ. Дараа нь тэр бүтээлээс дахин эш татсан тохиолдолд зөвхөн эхний зохиогчийн нэрийг дурдаад, бусад зохиогчийн нэрийг бичилгүй “ба бусад,” (“и др.,” “et al.,”) гэж товчилно. Жишээлбэл: Гантогтох ба бусад (2018)...

4.Өөр хэлээр хэвлэгдсэн эх сурвалжаас эшлэл авахдаа:

Үндсэн бичвэрт агуулгыг монгол хэлээр эшилж, харин зохиогчийн нэрийг тухайн хэлээр нь бичнэ. Жишээлбэл: Хувилбарууд нь уран сайхны үзэгдэл болохынхоо хувьд аман зохиолын динамикийн илрэл юм. Хувилбаруудад нэгдмэл учир зүй, үзэл санаа, саналга илт оршдог бөгөөд хуулбарлагдсан хэв шинж нь ч ижил байна (Аникин, 2007:54).

#### **Ном зүйд дараах шаардлагыг баримтална. Үүнд:**

- Эх сурвалжуудыг дугаарлахгүй.
- Ном зүй дэх эх сурвалжуудыг жагсаахдаа цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ. Хэрэв гадаад эх сурвалж ашигласан бол ном зүйг А.Монгол хэлээр, Б.Англи ба бусад хэлээр гэж ангилан бичнэ.
- Эшлэл аваагүй зохиогчийн нэрийг ном зүйд оруулахгүй. Өөрөөр хэлбэл, эшлэл, ном зүй тохирч байх ёстой.

#### **Ном:**

- *1 зохиогчтой бол:*  
Цэрэнсодном, Д. (2011). *Монгол ардын аман зохиолын тайлбарт дээж бичиг*. Улаанбаатар: Тод бичиг ХХК. [Tserensodnom, D. *Mongol ardiin aman zokhioliin tailbart deej bichig* [The explanatory anthology of Mongolian Folklore]. Ulaanbaatar: Tod bichig LLC. 2011.]
- *2 зохиогчтой бол*  
Нандинбилиг, Г., Дулам, С. (2020). *Монгол аман зохиолын онол II*. Улаанбаатар: МУИС пресс хэвлэлийн газар. [Nandinbilig, G., Dulam, S. *Mongol aman zokhioliin onol-II* [The theory of Mongolian Folklore-II]. Ulaanbaatar: MUIS press printing. 2020.]
- *3 ба түүнээс дээш зохиогчтой бол:*  
Байгалсайхан, С., Мөнхбаяр, Б., Билгүүдэй, Г., Алимаа, А., Сумъяа, Д. (2022). *Монгол утга зохиолын нэвтэрхий толь*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Baigalsaikhan, S., Mönkhbayar, B., Dilguudei, G., Alimaa, A., Sumiya, D. *Mongol utga zokhioliin neverterkhii toli* [Glossary of Mongolian literature]. Ulaanbaatar: Soyombo printing. 2022.]

#### **Өгүүлэл:**

- *1 Зохиогчтой бол:*  
Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). Өгүүллийн нэр. *Сэтгүүлийн нэр, Сэтгүүлийн гаралтын дугаар* (тухайн оны дугаар), Хуудасны дугаар. Жишээлбэл: Баясгалан, Т. (2021). Жангарч П.Рампилын хэлсэн “Дуншуургэрэл мангасыг Хонгор амьдаар барьсан бүлэг”-ийн гарал, уламжлал. *Аман зохиол судлал, XLII*: 28-48. [Bayasgalan, T. The origin and tradition of the “Chapter about hero Khongor captured Dunshuur Gerel monster” by jangarch P.Rampil. *Folklore Studies*, 2022, XLII: 28-48.]
- *ба түүнээс дээш зохиогчтой бол:*  
Өгүүллийн нэр. *Сэтгүүлийн нэр, Сэтгүүлийн гаралтын дугаар* (тухайн оны дугаар), Хуудасны дугаар. Жишээлбэл: Долгорсүрэн, Ж., Сайхан, Ж. (2021). Аялгуут аман соёлын бүтэц, төрөл зүйлийн онцлог. *Аман зохиол судлал, XLII*: 73-97. [Dolgorsuren, J., Saikhan, J. Structure and characters of types of sonic folklore culture. *Folklore Studies*, 2021, XLII: 28-48.]

**Холбоо барих утас: А.Алимаа 98111378, Ч.Заяасүрэн 80114704**

**ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Аман зохиол судлалын салбар**

2024.01.10